

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-4

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 5-15

<i>1.Байнгын хорооны тогтоолын төсөл /Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы 04 дүгээр сард Эдийн засгийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/</i>	5-6
<i>2.Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.12.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	6-12
<i>3.Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг нарын 7 гишүүн 2024.04.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	12-15

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны
04 дүгээр сарын 03-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 18 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 55.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 08 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Батлут;
Чөлөөтэй: Ч.Хүрэлбаатар, Б.Энхбаяр;
Эмнэлгийн чөлөөтэй: Х.Ганхуяг, Т.Доржханд.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хойшлуулах санал хэлж, хэлэлцүүлгийг хойшлуулав.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы 04 дүгээр сард Эдийн засгийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, мөн хэлтсийн референт А.Хонгорзул нар байлцав.

Байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг “Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы 04 дүгээр сард Эдийн засгийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ц.Цэрэнпунцаг: “Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы 04 дүгээр сард Эдийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 6
Бүгд: 12
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ц.Цэрэнпунцаг: “Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы 04 дүгээр сард Эдийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 14 цаг 15 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.12.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, мөн хорооны Үнэт цаасны газрын дарга Б.Дөлгөөн, Хяналт шалгалтын газрын дарга Б.Долгорсүрэн, Хуулийн хэлтсийн дарга Ж.Мөнх-Оргил, Сангийн яамны Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга Л.Сонор, мөн хэлтсийн зөвлөх Н.Ундраа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, Ё.Энхсайхан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, мөн хэлтсийн референт А.Хонгорзул нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, М.Оюунчимэг нарын тавьсан асуултад Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан хариулж, тайлбар хийв.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав. /Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т заасны дагуу хураалгах санал/

Ц.Цэрэнпунцаг: 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 4 дүгээр зүйлийн “4.1.34-өөс 4.1.39” дэх заалтын дугаарыг “4.1.35-аас 4.1.40” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 3

Бүгд: 10

70.0 хувь буюу гуравны хоёроос доошгүйн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 3 дугаар зүйлийн 19 дэх заалт буюу 43 дугаар зүйлийн 43.8 дахь хэсгийн “задруулахыг” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 4

Бүгд: 10
60.0 хувь буюу гуравны хоёроос доошгүйн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ц.Цэрэнпунцаг: Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Ц.Цэрэнпунцаг: 2.Төслийн 3 дугаар зүйлийн 19 дэх заалт буюу 43 дугаар зүйлийн 43.8 дахь хэсгийн “задруулахыг” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувь буюу гуравны хоёроос доошгүйн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 38 минутад хэлэлцэж дуусав

Гурав.Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг нарын 7 гишүүн 2024.04.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, Ё.Энхсайхан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, мөн хэлтсийн референт А.Хонгорзул нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг танилцуулав.

Төслийн үзэл баримтлалын талаар Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэгийн тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг хариулж, тайлбар хийв.

Ц.Цэрэнпунцаг: Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11

54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрэм
Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 51 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 43 минут үргэлжилж, ирвэл зохих 18 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж,
72.2 хувийн ирцтэйгээр 14 цаг 51 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:

ЭДИЙН ЗАСГИЙН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ц.ЦЭРЭНПУНЦАГ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим
14 цаг 08 минут.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Цэрэнпунцаг: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг эрье. Ингээд Байнгын хорооны ирцийг танилцуулъя. Доржханд гишүүн өвчтэй байна. Ингээд бусад нь ирсэн байна. Ингээд Байнгын хорооны гишүүдийн ирц хүрч, ирц хүрсэн тул өнөөдрийн Байнгын хорооны ирц 61,1 хувьтай бүрдсэн тул 2024 оны 4 дүгээр сарын 3-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлуудыг танилцуулъя. Хэлэлцэх асуудал 4 асуудал байна. 1.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэгт заасны дагуу 2024 оны 4 дүгээр сарын сард Байнгын хороогоор хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төсөл байна. 2-т Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Засгийн газар 2023 оны 12 сарын 22-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг. 3-д Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Улсын Их Хурлын гишүүн Учрал 2019 оны 2 сарын 20-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн, Бусад гэсэн эдгээр 4 асуудлыг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэхээр долоо хоногийн тов дараалалд орсон байна.

Ингээд 1-д, 1 Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн ахлагч Баттөмөр гишүүн хуулийн төслийн талаар тайлбараа хийх үү? Ингээд Баттөмөр гишүүний микрофоныг нээе.

Б.Баттөмөр: Та бүгдэд энэ өдрийн мэнд хүргэе. Энэ Мэргэжлийн нэгдсэн холбооны тухай хуулийн төсөл дээр бид нар одоо сүүлийн 2 сар гаруйн хугацаанд маш их идэвхтэй ажиллаж байна. Шийдэх одоо асуудлууд төрийн бус байгууллагууд, мэргэжлийн холбоонуудыг оруулах шаардлага одоо зайлшгүй үүсэж байна. Өчигдөр болбол бас хуралдаад ямар ч байсан долоо хоногоор хойшлуулъя гэсэн ийм шийдэлд одоо ажлын хэсэг хүрсэн. Энэ ажлын хэсэгт Нямаагийн Энхболд, хэн Мөнх-Оргил гишүүн, тэгээд хэн Ц.Мөнхцэцэг гишүүн, миний бие ингээд бид оролцож байгаа. Тийм учраас бэлтгэл хангагдаагүй байгаа учраас ирэх долоо хоног хүртэл хойшлуулах саналтай байна.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгийн ахлагч ахлагчийн саналаар хуулийн төслийг өнөөдрийн хэлэлцэх асуудлуудаас хасъя. Бусад гэсэн асуудлын хүрээнд өчигдөр буюу 2024 оны 4 сарын 2-ны өдөр өргөн мэдүүлсэн Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхээр Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөл дээр шийдвэрлэсэн. Ийм асуудлууд байна. Ингээд өөр саналтай гишүүд байна уу? Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё. Энэ дарааллаараа байгаа юу, зөв дарааллаараа байгаа биз дээ.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы 04 дүгээр сард Эдийн засгийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/

Хэлэлцэх асуудал 1. 2024 оны 4 дүгээр сард Байнгын хороогоор хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье. Төслийг та бүхэндээ уншиж танилцуулъя. Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы 4 дүгээр сард Эдийн засгийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.14 дэх заалт Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос тогтоох нь. 1. Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы 4 дүгээр сард хэлэлцэх асуудлын дараалал тогтоох тухай 42 дугаар захирамжид заасан Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хэлэлцэх цаглаварыг хавсралтаар баталсугай. 2. Хууль хэлэлцэх хугацааг тусгайлан заасан асуудал болон Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хэлэлцэхэд энэ цаглавар хамаарахгүй. 3. Энэ тогтоолын биелэлтийг хангаж хэлэлцэх асуудлын бэлтгэл хангахыг Улсын Их Хурлын Тамгын газар Д.Энхбатад үүрэг болгосугай.

Төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Гишүүд асуулт асууж, санал хэлж дууслаа. Ингээд санал хураалт явуулж эхэлье. Монгол Улсын Их Хурлын 2023 он 24 оны намрын ээлжит чуулганы 4 дүгээр сард Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай Байнгын хорооны

тогтоолын төслийг баталъя гэсэн томъёолоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Гишүүдээ, Оюунчимэг гишүүнээ саналаа санал хураалт. Баттөмөр гишүүн таны төхөөрөмж санал эсрэг гарсан байна. Цаглавараа бид нар баталж байгаа. Та горимын санал гаргах уу?

Б.Баттөмөр: Би энэ цаглавар батлах горимын саналыг бол тийм, цаглавар батлах төлөвлөгөөг бол дэмжиж байгаа юм. Сая тэгээд аппарат ажилласангүй, дахиж санал хураалтад явуулж өгнө үү.

Ц.Цэрэнцунцаг: Баттөмөр гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Саяын хураасан саналыг хүчингүй болгоё гэсэн томъёолоор саналын хураалт, санал хураалт явуулъя. Санал хураалт. Энэ дээр бас намрын гэдгийг нь би унисан л байна шүү дээ. Гишүүдийн 63,6 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ. Санал хураалт явуулж дууслаа. Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы, 2024 оны 4 дүгээр сард Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийн хэлэлцүүлэг дууслаа.

14.15 цаг

Хоёр. Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.12.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Дараагийн асуудалдаа оръё. Хэлэлцэх асуудал 2. Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье. Хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг Улсын Их

Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Т.Энхтүвшин танилцуулна. Энхтүвшин гишүүний микрофоныг нээе.

Т.Энхтүвшин: Баярлалаа. Ажлын хэсгийн танилцуулгыг уншиж танилцуулъя та бүхэндээ. Монгол Улсын ЗГ-аас 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг 2024 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Ажлын хэсэг 2024 оны 4 дүгээр сарын 2-ны өдөр хуралдаж, нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан зарчмын зөрүүтэй саналуудыг тусгасан төслийн эцсийн хувилбарыг төслийг хэлэлцэж дууссан. Ажлын хэсэг төслийг дэмжиж, Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж шийдвэрлэсэн. Байнгын хорооны эрхэм дарга, гишүүд ээ, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн төслүүдийг эдийн засгийн хэлэлцүүлэгт, эцсийн хэлэлцүүлэгт бид бэлтгэсэн талаарх танилцуулга, төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсэж байна.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгийн гишүүдийн нэрсийг танилцуулъя. Дэмбэрэлдашийн Баярсайхан СЗХ-ны дарга, Баттулгын Дөлгөөн СЗХ-ны Үнэт цаасны газрын дарга, Лувсандоржийн Сонор Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн газрын дарга, Бархасын Долгорсүрэн СЗХ-ны Хяналт шалгалтын газрын дарга, Жаргалсайханы Мөнх-Оргил СЗХ-ны Хуулийн хэлтсийн дарга, Нүрсэдийн Ундраа Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах зээл,

даатгалын хэлтсийн зөвлөх. Ажлын хэсгийн танилцуулгаас асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү? Харин дараад байна. Баттөмөр, Оюунчимэг гишүүнээр тасаллаа. Баттөмөр гишүүн асуултаа асууя.

Б.Баттөмөр: Үнэт цаасны тухай хууль боловсрогдож ажиллаад, эцсийн хэлэлцүүлэгтээ ороод явж байна. Энэ бол Монгол Улсын эдийн засагт бас чухал ач холбогдолтой ийм хууль батлагдах шатандаа ороод явж байна л даа. Энэ хууль бол хуулийг анх 22 оноос яригдсан юм. Тэгээд манай СЗХ-ныхон бол энэ дээр маш идэвхтэй сайн ажилласан. Тэгээд ярьж байгаад ер нь бас Засгийн газраар өргөн бариулах нь илүү ач холбогдолтой гээд Засгийн газраар өргөн бариулаад одоо ингээд явж байна.

Энэ Алсын хараа 2050, санхүүгийн салбарыг 2025 он хүртэл хөгжүүлэх төлөвлөгөө, Засгийн газрын мөрийн хөтөлбөр гээд олон асуудлууд энэ Үнэт цаасны тухай хуулийг баталж шинэчлэхээр тусгачихсан байгаа. Тэгээд энэ яг тусгачихсанахаа дагуу явж байна гэж ингэж үзэж байгаа юм. Ер нь болбол санхүүгийн зах зээлийн харилцаа болбол энэ хөгжингүй орнуудад бол нөгөө 60, 30, 10 гээд хавьцаа байдаг шүү дээ тийм ээ. Тэгэхээр манай энэ сүүлийн жилүүдэд яг энэ хөрөнгийн зах зээлийн үнэлгээ энэний үйл ажиллагаа их идэвхтэй явж байгаа. 11,9 их наяд төгрөгийн үнэлгээ бол ингэж гарчихсан байгаа. Өнөөдрийн 74 их наяд төгрөг гээд ДНБ-д харьцуулахад бол бас бага болох байх. Өнгөрсөн жилүүдийнхтэй харьцуулахад бол нэлээн өндөр тоо гардаг. Тэгээд энэний үр ашиг гэдэг юмыг л бид их сайн барьж ажиллах ийм шаардлагатай байгаа юм.

Энэ зохицуулалт хийх олон харилцаанууд юу яасан, ялангуяа энэ санхүүгийн зах зээл энэ хөрөнгийн зах зээлд болбол асар их тийм шинэлэг шинэ технологи, шинэ ажил, үйлчилгээнүүд нэвтэрч байгаа. Тэгэхээр энийг тухай бүр нь оруулаад явах болбол боломжгүй байдаг. Тэгэхээр энэ дээр бол нэлээн

алсыг харж хийж орж ирсэн. Тухайлбал манайд зохицуулалтгүй энэ биржийн бус арилжаа гээд бараг 2 их наяд төгрөгийн хөрөнгийн эх үүсвэрийг босгочихсон байгаа. Тэгээд зохицуулалтгүй байсан. Энэ хуульд бол зохицуулж орж ирж байгаа. Тэгээд нээлттэй ХК болоод IPO гаргана гэхээр маш их ажилтай байдаг, ажилтай байхаас ч өөр арга байхгүй. Тэгэхээр энэ биржийн бус арилжаагаар хийх нь болбол аж ахуй эрхлэгчид болбол бас их зөв зүйтэй ийм асуудал байгаа юм.

Төлбөр тооцооны стандарт гээд байдаг олон улсын түвшинд хүргэх алхмууд болбол энэ хуулиар хийгдэж өгч байгаа гэж ингэж ойлгож байгаа. Өнөөдөр Хөрөнгийн биржид 24 компани үнэт цаасаа гаргаад ажиллаж байгаа. 196 компани бүртгэлтэй байгаа. 30 хувь нь болбол тэр шаардлагыг нь хангаж байгаа төлбөр тооцоо тэр баримт бичиг гээд. Үлдэж байгаа 70 хувь нь болбол хангахгүй байгаа. Эд нарыг бол хангуулах талд нь бас тодорхой ийм ажлууд болбол хийгдээд явж байгаа гэж ойлгож байгаа. Энэ хөрөнгийн зах зээлд Монголд энэ мэргэжлийн хөрөнгө оруулагч нарыг оруулж ирэх чиглэлд бас энд тодорхой ажлууд санаанууд энд ороод явж байгаа. Ингэснээрээ болбол юу гэхээр бас энэ хөрөнгийн зах зээл хөгжих ийм боломжууд бол нээгдэнэ гэж үзэж байгаа юм л даа. Энэ нөгөө Глобал Кастодиан банк гээд бид нар ярьдаг шүү дээ. Энэ байгаа дотоодын кастодиан банкнууд байгаа. Энийг үйл ажиллагааг нь тодорхой болгож, эрх зүйн орчныг нь болбол бас нэлээн боломжийн болгож ирж байгаа гэж ингэж ойлгож байгаа. Манай, тэгээд цаашаагаа ер нь болбол энэ хөгжлийн.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Баттөмөр гишүүнд 1 минут нэмж өгье, асуултаа гүйцээгээд асуучихъя.

Б.Баттөмөр: Энэ Үнэт цаасны хууль баталснаараа хөрөнгийн зах зээл хүчтэй хөгжөөд явчихна гэж байхгүй, эдийн засгийнхаа бүтэц, энэ эдийн засгийнхаа хөгжилтэй холбоотой.

Яагаад гэхээр өнөөдөр банкнуудын хадгаламжийн дундаж нь 15 хувь байна шүү дээ жилийн. Тэгээд ямар ч хувьцаа компанид хувь үнэт цаасыг нь худалдаж авлаа гэхэд 15 хувийн өгөөж өнөөдөр Монголд байхгүй байгаа шүү дээ. Тийм учраас энэ эдийн засгийнхаа зохистой харилцаатайгаа уялдаж байж энэ хууль цаашидаа ажил болж явах юм гэдэг санааг л энд хэлэх гээд байгаа юм л даа. Энийг хийхгүйгээр цаашидаа боломж бол байхгүй. Энэ дээр бид нар их ажилласан, манай Энхтүвшин ажлын хэсгийн ахлагч. Тэгээд бид нар бас нэлээн сайн ажиллаж, манай СЗХ ч гэсэн мэргэжлийн туслалцаа үзүүлж ингэж гаргасан. Ингээд энэ хууль бол сайн хууль болж.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Баттөмөр гишүүн асуултаасаа илүү бараг санал хэлчихлээ тийм ээ. Тийм учраас Оюунчимэг гишүүн асуултаа асууя.

М.Оюунчимэг: Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд оруулж байгаа нэмэлт, өөрчлөлтүүдийн хувьд бол бас болж байна. Энийг бол дэмжиж байгаа. Бид нар сая бас Баттөмөр гишүүний хэлээд байгаа шиг Монгол Улс банкны салбар нь энэ илүү их зах зээлд ноёрхчихсон, хөрөнгийн зах зээлээ хөгжүүлэхгүйгээр эдийн засаг томрох, хөрөнгө оруулалтыг оруулж ирэх энэ зүйл бол хумигдмал байгаа. Тиймээс энэ зах зээл рүү илүү их ач холбогдол өгье гээд хууль, эрх зүйн хувьд бид бол нэлээн чухал, чухал хуулиуд гаргасан. Тэгээд бид нар сая ковидоос хойших ингээд зах зээлийн үнэлгээ судалгаануудыг хараад байхад CU, GS25-ын сүлжээнүүд орж ирсэн нь өөрөө энэ зах зээлд маш ашигтай ажилласан юм шиг тийм үзүүлэлтүүд гарсан байсан л даа. Тэгвэл энэ сүлжээгээр асар их хөрөнгө мөнгө гаднаас орж ирж байгаа юм уу эсвэл Монголоос гадагшаа гарах энэ тэр дээр асуудлууд бол байдаг. Энэ нь өөрөө яг хөрөнгийн зах зээлийг зөв голдирлоор явж байгаатай холбоотой юу эсвэл энд бас өөр асуудал байдаг юм болов уу? Энэ дээр Баярсайхан дарга СЗХ-ны даргын хувьд

бас нэг хариулт өгөөч. Мэдээж ийм том, том сүлжээ бол орж ирэх нь сайн хэрэг. Энэ бол энийг дагаад соёл орж ирж байгаа. Харин энэ маань яг зах зээлийнхээ жам ёсоор хөрөнгө оруулалт болоод ингээд явж байгаа юу? Энэ дээр бас нэг олон хүн ингээд бид нараас Эдийн засгийн байнгын хорооны гишүүний хувьд бас асуугаад байгаа. Тэгээд энийг асууж байгаа шалтгаан нь өөрөө энэ зах зээлийг бид нар бас зөв хөгжүүлэх, сайн хөрөнгө оруулагчдыг хөхиүлэн дэмжих гэдэг талаасаа бас ярьж байгаа.

Нөгөө талаасаа сая нэг баахан асуудал үүссэн шүү дээ. Нөгөө койноос болоод тийм ээ, өрөө байраа алдсан, асар их хөрөнгө мөнгөө алдсан гээд л. Бараг зарим нь амь насаа хорлоход хүрч байгаа. Онлайн тоглоомуудаас болоод бараг амиа хорлосон тохиолдлууд ч ингээд гарсан тухай ийм мэдээллүүд яваад байгаа л даа. Тэгээд энийг яг мэдээж хууль хүчний байгууллага хянадаг байх. Гэхдээ яг энэ дээр манай СЗХ юм уу та бүхнээс бас нэг тодорхой хяналт тавьдаг ч гэдэг юм уу эсвэл Монголбанктайгаа хамтраад юм уу зохицуулалт дээр хийх зайлиггүй эрх зүйн шаардлага байгаа болов уу? Энэ асуулт дээр би бас хариулт авахыг хүсэж байгаа. Яагаад гэвэл бид нар нэгэнт бас энэ нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа тохиолдолд зарим нэг зүйл дээр бас анхаарах юм уу, чагтлах зүйл оруулж өгөх хэрэгтэй байгаа юу, үгүй юү гэдэг асуудал байна.

3 дахь зүйл нь одоо нөгөө ЭТТ-н 1072 хувьцааны 2 дахь шатны ноогдол ашиг өнөөдөр өгч байна шүү дээ тийм ээ. Зарим хүмүүс нөгөө нэг хөрөнгийн брокерын нүүсээрээ дамжуулж авдаг. Зарим нь нөгөө брокер нь хаана байгаад байгаа, утасдаад миний хувьцааны мөнгө ороогүй байна гэхээр олдохгүй. Тэгээд хаана байдаг гэхлээр манайх энд үйл ажиллагаа явуулж байгаад хаачихсан байгаа, өөр газар оччихсон байгаа гэх мэтээр нөгөө хувьцааныхаа хувьцаа авсан хүмүүс нь тэр холбогдох гэхээр зарим брокерын нүүсүүд мэдээлэл нь

хангалтгүй байгаад байна гэсэн зүйл дээр бас бид нарт ингээд асуултууд ирж байсан. Яг ийм зүйлүүд байна уу? Хариуцлагатай яг энэ хувьцаа дээр ажиллаж байгаа үнэт цаасны зах зээлд орж байгаа компаниуд байришил нь, хаяг нь, мэдээлэл нь өөрөө ил тод шилэн байх ёстой. Тэгээд энэ дээр СЗХ яг бодит хяналт нь ямар байна вэ? Одоо яг энэ 1072 хувьцаа дээр ийм зүйлүүд гараад байгаа хүмүүст ямар зөвлөгөө өгөх вэ та нар? Ийм асуултуудад хариулт авъя.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгээс хариулаарай. Эхний 2 асуулт бол өнөөдрийн бид нар хэлэлцэж байгаа Үнэт цаасны зах зээлийн тухай хуультай холбоотой. 3 дахь нь бол өнөөгийн СЗХ-ны өнөөдрийн энэ нөхцөл байдал үүсэж байгаатай холбоотой ийм тусдаа асуулт асуулаа. Ингээд сайхан тодорхой хариулаад өгөөрэй. Ажлын хэсгийн 4 номер Баярсайхан дарга хариулъя.

Д.Баярсайхан: Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Сүүлийн үед энэ юу гэдэг юм convenient store гэж нэрлээд байгаа энэ олон нийтэд энэ сүлжээгээр 8 нэрийн болон бусад бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ явуулж байгаа ААН-үүдтэй холбоотой асуулт асуулаа гэж ойлголоо. GS25-н хувьд бол ХК хэлбэртэй биш учраас бид нар бол яг үйл ажиллагаа, салбар, бүтэц онцлогийг нь бол тийм ийм гээд хэлчхэж чадахгүй байна. СУ бол олон нийтээс санхүүжилт татсан, IPO хийсэн, 22 мянга гаруй хувьцаа эзэмшигчтэй ийм компани байгаа. Бид нар бол засаглалын хувьд бол бас их зөв зүйтэй компани юм байна гэж үзэж байгаа. Зүгээр шууд нүдэнд харагдахаас илүү бас нийгэмд маш олон үр нөлөөтэй байдаг юм байна лээ. Жишээлбэл 24/7-гоор хүнсээ бэлддэг, эрүүл ахуйн стандартыг хангуулдаг. Өвлийн улиралд бол дотор нь ороод дулаацахаас гадна, хөдөлмөрийн зах зээлд дээр цагийн үнэлэмжээр ялангуяа оюутнуудад хөдөлмөр эрхлэх боломжийг бий болгосон гээд маш олон давуу талууд байдаг юм байна лээ. Тэгээд ХК-д тавигдах бүхий шаардлагуудыг тавьж

ажиллаж байгаа. Тэгээд засаглалын хувьд бол харьцангуй сайн компани, ирээдүйд орох мөнгөн урсгалын аргаар бол анх хөрөнгийн үнэлгээг нь хийгдсэн. Тэр хүрээндээ бол СЗХ-ноос бол олон нийтийн компани болох зөвшөөрлийг нь өгөөд явж байгаа.

Мэдээж нөгөө Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийг зохицуулахтай холбоотой бол хууль, эрх зүйн зохицуулалт ороод, энэ хүрээндээ бол СЗХ-ны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт орсон. Хороо бол энэ виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч этгээдүүдийг бүртгэж байгаа. Өөрөөр хэлбэл энэ виртуал хөрөнгийн биржүүдийг бүртгэж байгаа. Биржүүд тухайн койн, токен байдаг юм уу энэ виртуал хөрөнгүүдийг өөрийнхөө бирж дээр тодорхой шаардлагууд тавиад стандартын хүрээнд бүртгэлийн үйл ажиллагаа хийгдэж байгаа. Хэдэн бирж байгаа билээ? 12 ийм виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч этгээд буюу ААН үйл ажиллагаа явуулж байгаа. Ер нь зүгээр энэ койн ч биш сүүлийн үед нийгэмд ялангуяа энэ залуучууд мөрийтэй бусад онлайн хэлбэрээр хохирох ийм үзэгдэл бол Монгол Улсад биш дэлхий даяар бол байж байгаа. Энэ хүрээндээ бол холбогдох байгууллагуудтай хамтарч ажилладаг. Ялангуяа энэ иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хүрээнд бол Монголбанк, боловсрол, Боловсролын яам, тэгээд СЗХ бол хамтраад иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр хэрэгжүүлдэг. Мөн дээрээс нь хууль хүчний байгууллагуудтай ялангуяа энэ цахим луйвар залилан. тийм ээ, энэ схемүүдээс урьдчилан сэргийлэх байдлаар бүхий л төрлийн сургалт олон нийтийг чиглэсэн хэвлэлийн бүхий л сувгуудыг ашиглаж ажиллаж байгаа. Гэхдээ мэдээж энэ талаар бол илүү их цаашидаа ажиллах шаардлага байгаа гэж харж байгаа.

ЭТТ ноогдол ашгийг иргэдэд олгохтой холбоотой бол ямар нэгэн хүндрэл байхгүй байх гэж бодож байгаа.

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үнэт цаасны данснуудаар дамжаад олгогдож байгаа. Байхгүйд нь бол НӨАТ-ын тийм ээ буцаалт дээр бүртгэгдсэн банкны данснууд дээр очиж байгаа. Бас хүүхдийн мөнгө олгогдож байгаа данснууд байдаг. Энэ бүх сувгаар хүргэгдэж байгаа учраас энэ дээр бол иргэдэд ямар нэгэн чирэгдэл бол үүсэхгүй байгаа гэж бодож байна. Ер нь бол Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв дээр бол давхардсан тоогоор 2,5 сая иргэн бол дансаа нээлгэчихсэн байгаа. Өөр юу асуусан билээ. Тийм, тэгээд үнэт цаасны тусгай зөвшөөрөлтэй компани бол 52.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Баярсайхан дарга гүйцээгээд хариулчихъя. Та цагийнхаа менежментийг сайн барина шүү.

Д.Баярсайхан: Үнэт цаасны энэ компанийн 52 компанийн мэдээлэл бол веб сайт дээр нээлттэй байж байгаа. Энд бол бүгд бол яг үйл ажиллагаагаа хэвийн тогтмол явуулж байгаа. СЗХ-ны *frs.mn* гээд сайтад эдгээр ҮЦК-удын хаяг байршил, холбоо барих утас гээд энэ бүх мэдээлэл бол нээлттэй байгаа. Хэрвээ энүүгээр ямар нэгэн байдлаар холбогдож чадахгүй бол манай СЗХ-той бол шууд холбогдоод энэ ҮЦК-удын бүхий л төрлийн олон нийтэд мэдээлэл хүргэгдэх энэ мэдээллүүдийг бол чөлөөтэй авч ажиллах боломжтой байгаа.

Ц.Цэрэнпунцаг: Оюунчимэг гишүүн нэмж асууя, нэмэлт асуулт асууя.

М.Оюунчимэг: Би асуулт асуухгүй нэг үг хэлчихье. Сая Баярсайхан дарга хэлж байна. Тэр онлайн мөнгөө алдахгүй байх тэр элдэв мөрийтэй болон янз бүрийн хонжворт тоглоом тоглоомуудаас болоод иргэд янз бүрийн хэлбэрээр бие махбодын болоод санхүүгийн хохирол амсаж байгаа. Тэгэхээр бид нар танин мэдүүлэх сурталчилгаа сайн хийж байгаа гээд байгаа. Гэхдээ сайн хийгээгүй

хангалтгүй байгаа шүү. Энэ дээр та нар бас тэр үнэхээр Боловсролын яамтай хамтраад бүр тодорхой тийм цагаас тийм явна, өдөрт ингэдэг, энийг нь бид мэдээллийг нь харж байх ёстой юм байна гээд маш сайн мэдээллүүдээ өгч байх хэрэгтэй.

2-т нь одоо яг энэ хувьцаа өнөөдөр 2 дахь хувьцаагаа ЗГ-ын зүгээс өгч байна. Бид Улсын Их Хурлаас Эдийн засгийн байнгын хорооноос бас ЭТТ компани маань ашигтай ажилласан. Энэ хувьцаагаа ард иргэддээ өгөх ёстой гэсэн хатуу байр суурийг бол бид нар баримталж бас тогтоолоор үүрэг чиглэл өгсөн. Өнөөдөр ЗГ энэ сайн хэрэгжүүлээд явж байна. Тэгэхээр иргэдэд та бүхэн ийм 25 компаниар энэ хувьцаа чинь явж байгаа. Асуудал үүсвэл энэ утсаар ингэж холбогдоорой энэ тэр гэдгээ та бүхэн минь бас мэдээллээ сайн өгч байгаарай гэж хэлье.

Ц.Цэрэнпунцаг: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн боловч найруулгын болон дугаарлалтын зөрүүг арилгах зайлигүй шаардлагатай 2 саналын томъёолол байна. Эдгээр саналуудыг хуралдаанд оролцсон гишүүдийн 2/3 нь дэмжиж байж санал дэмжигдэх тул та бүхэн саналаа өгөхдөө бас анхааралтай байж саналаа өгөөрэй. Ингээд энэ 2 саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Энэ дээр байна уу? 1-д 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 4 дүгээр зүйлийн 4.1.34-өөс 4.1.39 дэх заалтын дугаарыг 4.1.35-аас 4.1.40 гэж өөрчлөх. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо.

Би энэ дээрээ тайлбар өгье. Яагаад энэ дугаарлалт өөрчлөлт орох болов гэхээр зэрэг Учрал гишүүний өргөн Цахим гарын үсгийн хууль батлагдахад энд дагаж хамт өөрчлөлт орсон Үнэт цаасны зах зээлийн тухай хууль дээр нэмэлт орохдоо энэ дугаарлалт хийсэн давхцал үүсээд байгаа юм байна. Тэгээд энэ давхцаж байгаа дугааруудыг

шилжүүлж байгаа юм. Тэгээд энэ саяын миний уншсан саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Гишүүдээ бүгд анхааралтай саналаа өгөөрэй. 66,6 хувиас дээш дэмжиж байж саяын санал дэмжигдэнэ шүү. Гишүүдийн 70 хувь нь дэмжиж санал дэмжигдлээ.

2 дахь зарчмын зөрүүтэй санал. Төслийн 3 дугаар зүйлийн 19 дүгээр, 19 дэх заалт буюу 43 дугаар зүйлийн 43.8 дахь хэсгийн задруулахыг гэснийг хасах. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. Би саналаа тайлбарлая. Энэ анхны хэлэлцүүлгийн үед хурал даргалагч Улсын Их Хурлын дэд дарга Мөнхбаатар дарга найруулгын чиглэл, найруулгаар сайжруулж, найруулгын, найруулгын сайжруулж, найруулгын дээр нь сайжруулах ийм чиглэл өгсний дагуу энэ дээр нь энэ найруулгын санал орж ирж байгаа юм байна шүү. Ингээд саяын миний уншсан саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Гишүүд. Баттөмөр гишүүн таны санал эсрэг гарсан байна. Тийм учраас Баттөмөр гишүүн та горимын санал гаргана уу. Таны санал эсрэг гарсан байна.

Б.Баттөмөр: Миний энэ аппарат ажиллахгүй байна. Би энийг сольж сууя, дахиж санал хураалгаж өгөөч.

Ц.Цэрэнпунцаг: Баттөмөр гишүүний санал хураах аппарат ажиллаагүй тул саяын хураасан санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Яах вэ саналаа хүчингүй болгож байгаа, одоо би дараа нь яагаад. Гишүүд саналаа өгөөрэй. Дараа нь хэн байна вэ, энд хэн байна вэ, Бат-Эрдэнэ байна. Гишүүдийн 72,7 хувь нь дэмжиж, санал дэмжигдэж саяын санал хүчингүй болсон тул дахин санал хураалт явуулъя. Санал хураалт. Гишүүдийн 80 хувь нь дэмжиж, зарчмын зөрүүтэй санал дэмжигдлээ. Санал хураалт явуулж дууслаа.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч байгаа юм байна, Т.Энхтүвшин гишүүн уншиж танилцуулна.

14.38 цаг

Гурав.Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг нарын 7 гишүүн 2024.04.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Дараагийн асуудалдаа оръё. Хэлэлцэх асуудал 3. Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье. Хууль санаачлагчийн илтгэлийг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт төрөөс гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүнд газрыг төлбөр, хугацаатайгаар болон хуульд заасан бусад болзол журмаар ашиглуулж болно гэж заасан. Мөн Газрын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2-т гадаад улс, олон улсын байгууллага, хувийн хуулийн гадаадын хуулийн этгээдэд газрыг тодорхой хугацаагаар түрээс, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр ашиглуулах талаар шийдвэр гаргах асуудал нь Улсын Их Хурлын бүрэн эрхийн асуудал гэж заасан бөгөөд уг газрын зааг, ашиглах журмыг ЗГ тогтооно гэж, мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.6-д заасан байна.

Түүнчлэн Газрын тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5-д гадаадын хөрөнгө оруулалттай ААН-д энэ хуулийн

дагуу газрыг тусгай зориулалт, хугацаа, болзолтойгоор ашиглуулах бөгөөд уг хугацааг ЗГ тогтооно гэж заасан байдаг. Дээрх хуулийн зохицуулалтууд нь гадаадын иргэн, хуулийн этгээдэд газрыг ашиглуулах асуудлыг зохицуулж байна. Гэтэл Хөрөнгө оруулалтын тухай хуулиар гадаадын хөрөнгө оруулагчид газрыг 100 жил хүртэлх хугацаагаар эзэмшүүлэх ашиглуулах асуудлыг зохицуулж байгаа нь Монгол Улсын Үндсэн хууль болон газрыг иргэн, аж ахуйн нэгж байгууллагад эзэмшүүлэх ашиглуулахтай холбогдсон харилцааг зохицуулдаг Газрын тухай хуультай тус тус зөрчилдөж байна.

Монгол Улсын ЗГ-аас 2023 оны 6 дугаар сарын 23-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д, 1.1-д хөрөнгө оруулагчид газрыг 15-аас 60 жил хүртэл жилээр гэрээний үндсэн дээр ашиглуулах, уг хугацааг гэрээний анхны нөхцөлөөр нэг удаа 40 хүртэлх жилээр сунгах хөрөнгө оруулалтын татварын бус урамшууллыг үзүүлж болно гэж тусгажээ. Энэ зохицуулалт нь мөн адил газрыг гадаадын иргэн, хуулийн этгээдэд эзэмшүүлэхдээ тодорхой хугацаа, болзол, журмын дагуу ашиглуулахаар заасан Монгол Улсын Үндсэн хууль болон Газрын тухай хуультай тус тус зөрчил зөрчилдөж байна.

Түүнчлэн иргэд, олон нийтийн зүгээс энэ асуудалд анхаарал хандуулж, Улсын Их Хурлын албан ёсны цахим системээр дамжуулан саналаа илэрхийлсэн, илэрхийлсээр байгаа бөгөөд иргэн Н.Номун-Эрдэнээс газрыг гадаадын иргэнд 100 жилээр ашиглах эзэмшихийг цуцлах сэдэвтэй нийтийн өргөдлийг Улсын Их Хурлын цахим системд 2024 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр гаргасан бөгөөд уг өргөдлийг 100167 иргэн дэмжиж саналаа өгөөд байна. Иймд хөрөнгө оруулагчид үзүүлэх татварын бус хөрөнгө оруулалтын дэмжлэгийн нэг хэлбэр болох газрыг 60 жил хүртэл, 60 хүртэл жилээр гэрээний

үндсэн дээр эзэмшүүлэх ашиглуулах, уг хугацааг гэрээний анхны нөхцөлөөр нэг удаа 40 хүртэл жилээр сунгах зохицуулалтыг тусгасан заалтыг Хөрөнгө оруулалтын тухай хуулиас хасах өөрчлөлт бүхий хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу? Асуулт цуг явчих уу? Асуулт асууж, асуулт асуух гишүүн байна уу? Энэ ингээд юу бичээд хаячихсан юм та нар. Оюунчимэг гишүүнээр тасалъя. Оюунчимэг гишүүний микрофоныг нээе.

М.Оюунчимэг: Их Хурал дээрээ Эдийн засгийн хөгжлийн яамнаас оруулж ирсэн Хөрөнгө оруулалтын тухай хуулийн төсөл бол бас Их Хурал дээр байгаа гэж би ойлгож байгаа шүү дээ тийм ээ. Энэ хууль дээрх тэр нөгөө газартай холбоотой асуудлыг бүхлээр нь хассан гэж нөгөө хууль санаачлагчид яриад байсан. Одоо энэ орж ирж байгаа бол Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт гэдгээр хөрөнгө оруулалтын сан гэж орж ирж байгаа юм байна. Ингэж орж ирэхдээ тэр Хөрөнгө оруулалтын тухай хуульд заасан газар эзэмшүүлэх өмчлүүлэхтэй холбоотой заалтыг тэр чигээр нь хасаж байгаа юм байна гэж би ойлголоо. Энэ Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хамгийн гол үзэл баримтлал энийг бид баталснаараа ямар асуудлыг шийдэж үр дүн нь ингэж гарна гэсэн тийм тооцоо судалгаа ямар байгаа вэ?

Ц.Цэрэнпунцаг: Энэ 2013 онд баталсан Хөрөнгө оруулалтын хууль дээр байгаа зүйл, заалтыг хасах гэж байгаа шүү дээ. Саяын энэ өргөн барьсан Хүрэлбаатар сайдын өргөн бариад, одоо Их Хурал дээр явж байгаа хууль бол, хууль биш 13 онд, байна уу танд, танилцуулга дээрээ байгаа шүү, 13 онд батлагдсан Хөрөнгө оруулалтын хууль. Эндээс энэ заалтыг хасаж байгаа юм. Би сая энэ нөгөө танилцуулга дээр та

Оюунчимэг гишүүнээ хамгийн гол нь Газрын тухай хууль байна шүү дээ, газрын харилцааны Газрын энэ хууль дээр бол одоо энэ харилцааг бол бүрэн зохицуулж байна гээд.

Газрын газрын тухай хуулийн 17-ын, 17 дугаар зүйлийн 17.1.2-т Монгол Улсын Их Хурлын бүрэн эрхэд эрхийг, эрх дотор бол энэ гадаадын улс орон, гадаадын олон улсын байгууллага, гадаадын хуулийн этгээдүүдэд газрыг түрээс, түрээсээр, мөн төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд эзэмшүүлэх энэ асуудал бол Улсын Их Хурлын бүрэн эрхийн асуудал гэж. Мөн энэ Газрын тухай хууль дээр ЗГ-т энэ газрыг газрын зааг, ашиглах журмыг бол ЗГ тогтооно. Мөн Газрын хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5-д гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид энэ хуулийн дагуу газрыг тусгай зориулалт, хугацаа, болзолтойгоор ашиглуулах бөгөөд энэ хугацааг ЗГ тогтооно гээд ингээд Газрын хууль дээрээ бүрэн зохицуулагдаж байгаа хуулийг өнөөдөр бид нар дахиад Хөрөнгө оруулалтын хууль дээр газрын энэ зүйл, заалт оруулж ирж, ингээд бас энд иргэдийн дунд ч ийм будилаантай, гишүүд дунд ч хууль тогтоогч ч гэсэн хоорондоо энэ бас нэлээн мэтгэлцээн явагддаг, маргаан мэтгэлцээн гардаг, саналын зөрөлдөөн их гардаг. Ер нь ингэж явахгүй, цаашидаа нэг зарчим барьж явъя гэсэн нэг ийм бодлого зарчимтай байя. Нэг зарчим нь бол өнөөдөр бид нар Татварын ерөнхий хуулиар бол татварынхаа бүх зохицуулалтыг хийе. Өөр бусад хуулийг орж ирж, бусад хуулийг дагуулж орж ирээд засахдаа дагуулаад энд татварыг хөнгөлдөг, чөлөөлдөг, татвартай холбоотой асуудлуудыг бол энэ бусад хуулиар зохицуулахгүй гээд энэ зарчим өнөөдөр үйлчилж байгаа.

Яг энэтэй адилхан газар бол бидний тусгаар тогтносон улсын үндэс суурь мөн, эмзэг сэдэв мөн. Тэгэхээр энэ Газрын тухай хуулиараа л газрынхаа асуудлыг шийддэг байя. Бусад хөрөнгө оруулалт ингээд бусад хуулиуд дээр нь

газрын асуудлаар энэ зүйл, заалт оруулж ингээж шийдэхгүй, явахгүй байя гэдэг л ийм л агуулга цаана нь байгаа юм. Оюунчимэг гишүүн нэмж асуулт асууя. Оюунчимэг гишүүний микрофоныг нээе.

М.Оюунчимэг: Тэгэхээр нөгөө ЗГ-аас Хөрөнгө оруулалтын тухай хуулийг бол өргөн барьчихсан байгаа. Түүн дээр яг саяын Цэрэнпунцаг тэргүүтэй гишүүдийн өргөн барьсан энэ хуулийн төслөөр бол тэр хуулийн 12.1.1 дэх заалтыг хүчингүй болго. Өөрөөр хэлбэл сая таны тайлбарласан нөгөө газрын тухай гэснийг нь хасаж байна, 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийн газрын тухай гэснийг хасах буюу өөрөөр хэлбэл нөгөө 100 жил хүртэл эзэмшүүлэх өмчлүүлэх гээд баахан маргаан дагуулсан энэ асуудлыг бол тэр чигээр нь хасаад, одоо Газрын тухай хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиараа явах ийм хуулийн төсөл нэмэлтээр оруулж ирж байгаа юм байна гэж би ойлгож байна.

Тэгэхээр Хөрөнгө оруулалтын тухай хууль энэ 2 маань нэгтгэгдээд хэлэлцэгдээд явах уу эсвэл энэ нь тусдаа Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт гэдгээр тусдаа хуулийн төсөл болоод хэлэлцэгдээд явах уу? Яагаад гэвэл хүмүүс Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт гэхээр нөгөө хууль энэ 2 нэг гэж зарим нь ойлгож байна. Зарим нь болохоор тэр газартай холбоотой хэсгийг нь хасаад энэ хууль цаашаа.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Одоо ЗГ-аас өргөн барьсан тэр төсөлтэй бол энэ огт хамаагүй. 2013 онд батлагдсан газрын юуны Хөрөнгө оруулалтын тухай хууль байна шүү дээ, тэр хууль дээрээс л энэ заалтыг хасах гэж байгаа санал. Тийм, одоо жишээлбэл энэ л дээ. Ер нь сая би тайлбарлаад байна Оюунчимэг гишүүнээ. Ер нь бид нар ингээд л газрын асуудал, бусад хуулиудаар газрын асуудлуудыг ингээд шийдээд л яваад байвал жишээлбэл өнөөдөр Аялал жуулчлалын тухай хууль байх юм бол бас

л газартай л холбоотой тийм ээ, аялал жуулчлалын отог байгуулах тухай гээд л газраа салгаад л аваад явчихна, бэлчээр гээд л тусдаа, хөдөө аж ахуй, жишээлбэл өнөөдөр бид нар хэлэлцээд л байж байна. Малчдын малчин өрхийн холбооны тухай хууль гээд л явж байна. Тэгвэл бас л газрын асуудал энэ дээр чинь яригдаад л явна, өнөө бэлчээрийн асуудал гээд. Ингээд энэ газраа бид нар нэгдсэн нэг хуулиар зохицуулж явахгүй бол ерөөсөө энэ замбараагаа алдах юм байна. Тэгээд хоорондоо зөрчил их үүсэх юм байна.

Энэнээс нь үүдээд ард иргэдийн дунд хүртэл буруу ойлголт түгэх, энэ нь цаашаа янз бүрийн байдлаар мушгиж гуйвуулагдаад ингээд үл ойлголцох ийм байдлууд их үүсээд байгаа учраас бол ер нь Газрын тухай хуулиараа зохицуулж явъя л гэж ингэж, тийм ийм үзэл баримтлалтай л энэ хуулийн энэ зүйл, заалтыг хасъя гэж ингэж л оруулж ирж байгаа юм. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Ингээд хуулийн үзэл баримтлалтай холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу? Энэ чинь энгийн олонхоор болно тийм ээ. Алга байна. Гишүүд үг хэлж дууслаа. Ингээд санал хураалт явуулж эхэлбэ.

Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт явуулж, явуулъя. Санал хураалт. Гишүүдийн 54,5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ. Санал хураалт явуулж дууслаа. Ингээд хуулийн төслийн хэлэлцсэн, төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал гаргах, Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Ундром танилцуулна. Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг дууслаа.

14.51 цаг

*Эдийн засгийн байнгын хорооны
өнөөдрийн хуралдаан үүгээр өндөрлөж
байна.*

*Ингээд Байнгын хорооны
хуралдаанд идэвхтэй оролцсон
гишүүддээ баярлалаа.*

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.УЯНГА*

